



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2022 оны 12 сарын 06 ны  
өдрийн 6031 дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН  
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Цахим гарын үсгийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4, 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Харилцаа холбооны зохицуулах хороонд тус тус үүрэг болгосугай.

САЙД  Н.УЧРАЛ



996544

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын  
2022 оны 11 дүгээр сарын 21-ны өдрийн  
А/81 дугаар тушаалын хавсралт

## ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМД ТАВИГДАХ ШААРДЛАГА

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.1-д заасан тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд (цаашид “тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх)-ийн гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага болон аюулгүй байдлын хяналт, нийтийн түлхүүрийн дэд бүтэц (цаашид “НТДБ” гэх)-д оролцогч талуудад холбогдох харилцааг тодорхойлоход оршино.

1.2.Энэхүү журмыг Нийтийн түлхүүрийн дэд бүтцэд оролцогч талууд болох Монгол Улсын үндэсний суурь гэрчилгээжүүлэх байгууллага /цаашид “МУҮГБ” гэх/, тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний бүртгэлийн нэгж үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

1.3.Энэхүү журмыг Цахим гарын үсгийн тухай хууль, “RFC3647 ITU-T Internet X.509 Public Key Infrastructure Certificate Policy and Certification Practices Framework”-д нийцүүлэн боловсруулсан болно.

Тайлбар: “RFC 3647” гэж “Интернэтийн инженерчлэлийн мэргэшсэн баг”-ийн гишүүдийн боловсруулсан нийтийн түлхүүрийн дэд бүтцийн бодлогын болон гэрчилгээжүүлэлтийн аргачлалыг;

“ITU-T Internet X.509” гэж “Олон улсын цахилгаан холбооны байгууллага”-ын стандартчиллын хэлтсээс гаргасан нийтийн түлхүүрийн дэд бүтцийн бодлоготой холбоотой стандартыг.

1.4.Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журмыг боловсруулахад ашиглах жишиг, загварыг энэ журмын хавсралтад тодорхойлно.

### Хоёр.Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага

2.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журмыг боловсруулж, батлахдаа гэрчилгээний бодлогыг тодорхойлох бөгөөд уг бодлогод нийцсэн байна.

Тайлбар: “Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журам” гэж тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, үйл ажиллагааны үндсэн дэг, тоон гарын үсгийн гэрчилгээ /цаашид “гэрчилгээ” гэх/, түүний түлхүүрийг олгох, удирдах, хүчингүй болгох болон өөрчлөхөд ашиглах аргачлал болон аюулгүй байдлын хяналтыг тодорхойлсон баримт бичгийг ойлгоно;

“Гэрчилгээний бодлого” гэж гэрчилгээг ашиглах дүрэм, гэрчилгээний нэр төрөл, зохион байгуулалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг, хариуцлага, төлбөр хураамж, нууцлал, аудит, бүртгэлийн талаар баримтлах үндсэн чиглэлийг ойлгоно.

2.2.Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд дараах мэдээллийг тусгана:

- 2.2.1. танилцуулга;
  - 2.2.2. мэдээллийг нийтлэх;
  - 2.2.3. таньж, баталгаажуулах;
  - 2.2.4. хүн, хуулийн этгээд гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх, гэрчилгээ олгох;
  - 2.2.5. удирдлага, үйл ажиллагааны болон биет хяналт;
  - 2.2.6. техникийн аюулгүй байдлын хяналт
  - 2.2.7. хүчинтэй болон хүчингүй гэрчилгээний жагсаалтын профайл;
  - 2.2.8. нийцлийн аудит, үнэлгээ;
  - 2.2.9. үйл ажиллагааны болон эрх зүйн бусад асуудал.
- 2.3. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах баримт бичгийг баталж, мөрдөнө:
- 2.3.1. мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам;
  - 2.3.2. сургалтын болон хэрэглэгчийн гарын авлага;
  - 2.3.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн түлхүүр, гэрчилгээний ашиглалтын төлөвлөгөө;
  - 2.3.4. хүний нөөцийн бодлого, журам;
  - 2.3.5. цахим шуудан ашиглах журам.

### **Гурав. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны аюулгүй байдлын хяналт**

- 3.1. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журмын аюулгүй байдлын хяналт нь дараах хяналтаас бүрдэнэ:
- 3.1.1. удирдлага, үйл ажиллагааны болон биет хяналт;
  - 3.1.2. техникийн аюулгүй байдлын хяналт.
- 3.2. Энэ журмын 3.1.1-д заасан хяналтад аюулгүй байдлын техникийн бус арга хэмжээг тодорхойлно.
- 3.3. Энэ журмын 3.2.2-т заасан хяналт нь компьютерын аюулгүй байдлын хяналт, үйл ажиллагааны мөчлөгт тавигдах техникийн хяналт, сүлжээний аюулгүй байдлын хяналтаас бүрдэх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шифрлэж хувиргалтад оруулж үүсгэсэн түлхүүр, идэвхжүүлэх өгөгдлийг хамгаалахын тулд хэрэгжүүлж буй аюулгүй байдлын арга хэмжээг тодорхойлно.
- 3.4. Компьютерын аюулгүй байдлын хяналтад компьютерын аюулгүй байдлын шийдлүүд, тэдгээрийг удирдах, шийдлийг баталгаажуулах үйл явцыг тодорхойлно.
- 3.5. Үйл ажиллагааны мөчлөгт тавигдах техникийн хяналтад гэрчилгээний үйлчилгээнд ашиглаж буй системийн хөгжүүлэлт, аюулгүй байдлын удирдлагын хяналт, хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлно.
- 3.6. Сүлжээний аюулгүй байдлын хяналтад эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хэрэгжүүлэх, зохион байгуулах, мэдээлэл солилцох, үйлчилгээний онцлогоос шалтгаалан ялгаатай SSL гэрчилгээ ашиглахыг тодорхойлно.